




**МОНГОЛ
АРДЫН НАМ**

**ЗАВХАН АЙМГИЙН
МОНГОЛ АРДЫН НАМЫН
МӨРИЙН ХӨТӨЛБӨР
/ 2020-2024 /**

Улиастай 2020 он



**ЗАВХАН АЙМГИЙН МОНГОЛ АРДЫН НАМЫН МӨРИЙН
ХӨТӨЛБӨР / 2020-2024 /**

Завхан аймгийн Монгол Ардын Нам энэ удаагийн орон нутгийн сонгуульд оролцох мөрийн хөтөлбөрөө МАН-ын 2020-2024 оны мөрийн хөтөлбөрийн суурь үзэл баримтлалыг үндэслэн боловсрууллаа. Энэ мөрийн хөтөлбөр нь 5 бүлэг 14 дэд зорилт, 139 заалт, арга хэмжээнээс бүрдэнэ.

Нэг: ХҮНИЙ ХӨГЖЛИЙН БОДЛОГО


Монгол Улсын Засгийн газар 2016 оноос нийгмийн хамгааллын тогтолцоог сайжруулах, иргэдийн орлогыг нэмэгдүүлэх, амьдралын чанарыг дээшлүүлэх арга хэмжээнүүд авснаар зохих үр дүнд хүрсэн.

Энэ зорилтын хүрээнд “Элэг бүтэн Монгол”, “Эрүүл шүд-Эрүүл хүүхэд” хөтөлбөрийг хэрэгжүүлж, тав хүртэлх насны хүүхдийн эмийн зардлыг эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжүүлэх эрх зүйн орчинг бүрдүүлэв. Хүүхэд бүр цэцэрлэгт хамрагдах боломжийг бүрдүүлж, сургуулиудын материаллаг баазыг сайжруулав. Залуучуудын хөгжлийг дэмжих хуулийг анх удаа батлан хэрэгжүүлж, гэр бүл, хүүхэд, залуучуудын болон тусгай хэрэгцээ (хөгжлийн бэрхшээл)-тэй иргэдийн хөгжлийг дэмжиж ажиллав.

“Цалинтай ээж” хөтөлбөр хэрэгжүүлж төрүүлж, өсгөсөн хүүхдийн тоогоор эхчүүдийн нийгмийн даатгал төлсөн хугацааг 1.5 жилээр нэмэгдүүлэн тооцдог боллоо. Бага тэтгэвэр авч байсан ахмадуудын тэтгэврийг нэмэгдүүлж, зөрүүг багасгаж, малчдын тэтгэврийн насыг 5 жилээр наашлуулж, малчид, хувиараа аж ахуй эрхлэгчдэд нийгмийн даатгалын шимтгэлээ нэг удаа нөхөн төлөх эрх зүйн орчинг бүрдүүлэв.

Азай буурлууддаа жилд 2 удаа “Насны хишиг” олгож, тэтгэвэр барьцаалсан зээлийг төрөөс нэг удаа төлөх тухай хууль баталж, ахмадын зээлийг тэглэж, тэтгэврийн зээлгүй ахмадуудад нэг сая төгрөгийн үнэт цаас эзэмшүүлэх шийдвэр гаргасан.

Ирэх дөрвөн жилд амжилттай хэрэгжиж байгаа нийгмийн хамгаалалын бүх төсөл, хөтөлбөрөө үргэлжлүүлж, улам өргөжүүлнэ. Нийгмийн даатгалын тогтолцоонд эрс шинэчлэл хийж, хуримтлалын нэгдсэн сангийн тогтолцоонд үе шаттайгаар шилжинэ. Нийгмийн даатгал төлдөг хүн бүр тэтгэвэр, эрүүл мэндийн үйлчилгээнээс гадна орон сууцтай болох, мэргэжил, боловсролоо дээшлүүлэх боломжийг



бүрдүүлнэ. Үндэсний өв соёл, соёлын бүтээлч үйлдвэрлэлийн шинэ салбарыг хөгжүүлнэ. Хөдөлмөр эрхлэлтийг бүх талаар дэмжиж, дундаж давхаргын эгнээг өргөжүүлнэ.

1.1. “ХҮНИЙ ХӨГЖИЛ - ХӨГЖЛИЙН ТҮҮЧЭЭ”

1.1.1 Өрхийн үйлдвэрлэл, гарааны бизнес эрхлэгчдэд “Бизнесээ эхэл-Бизнесээ хөгжүүл” сургалт явуулж шаардлагатай мэдлэг, ур чадвар олгох цогц арга хэмжээг хэрэгжүүлнэ.

1.1.2 Гарааны бизнес эрхлэгчдийг ЖДҮДС, ОНХС, СХС, ХЭДС-ийн хөнгөлттэй зээл тусламжинд хамруулах, зуучлах замаар үйл ажиллагааг дэмжинэ

1.1.3 Аймгийн ХХҮГ-т бүртгэлтэй ажил идэвхтэй хайж байгаа иргэдийг судалж мэргэшүүлэх, бүлэг нөхөрлөл болгон хөдөлмөр эрхлэлтийг дэмжинэ.

1.1.4 Жижиг, дунд үйлдвэрлэл эрхлэгчдийг МСҮТ, Политехник коллежийн инкубац / ментор / -ын үйлчилгээнд хамруулан бойжуулж, Ментор, ментигийн гэрээтэй бизнес эрхлэгчид үйлчлүүлэгчийн тоо, чадавхийг нэмэгдүүлнэ

1.1.5. Иргэдийн туршлага, ур чадвартаа түшиглэн хувиараа хөдөлмөр эрхлэх боломжийг дэмжиж, шаардлагатай техник, тоног төхөөрөмжөөр хангаж хамтран ажиллах бүлэг, нөхөрлөлийг дэмжинэ.

1.1.6. Орлого багатай иргэдийн цалингаас суутгах хувь хүний орлогын албан татварыг 2 дахин бууруулна


1.2 “ЭРҮҮЛ ИРГЭН- ЭЛЭГ БҮТЭН АМЬДРАЛ”

1.2.1. Иргэдийн эрүүл мэндийн нэгдсэн мэдээллийн санг үүсгэж, аймаг, сумдын эмнэлгийн оношилгоо, мэдээллийг гурав дахь шатлалын эмнэлгүүд, бүсийн оношлогоо эмчилгээний төвүүдтэй цахимаар солилцох тогтолцоог бүрдүүлж, иргэд жил бүр иж бүрэн үзлэг шинжилгээнд хамрагддаг болно.

1.2.2 Эмч, сувилагч, эмнэлгийн ажилтны нийгмийн баталгаа, хөдөлмөрийн үнэлэмж, урамшууллыг инфляцын түвшинтэй уялдуулж, үе шаттай нэмэгдүүлнэ.

1.2.3. Амжиргааны баталгаажих түвшингээс доогуур орлоготой иргэдэд тусламж үйчилгээний “Цахим карт” олгоно

1.2.4. Эрүүл мэндийн байгууллагын үйлчилгээ, эмийн хөнгөлөлт авах зэрэг цахим эрүүл мэндийн системийг бүрэн нэвтрүүлж, эмчлүүлэгчийн нууцлалыг хангаж, зардал, хүлээгдэл, чирэгдлийг бууруулна.



1.2.5. “Элэг бүтэн Монгол”, “Энх бүсгүй”, “Хавдрын эсрэг хамтдаа”, “Эрүүл шүд-Эрүүл хүүхэд” хөтөлбөрүүдийг үргэлжлүүлэн, хүүхдийн хоолойн архаг (ангина) өвчнийг эрт илрүүлэн эмчлэх, ирээдүйд учрах эрүүл мэндийн эрсдэлээс бага насанд нь сэргийлэх “Эрүүл ирээдүй” хөтөлбөрт хамруулна.

1.2.6. “Эрүүл чийрэг эр хүн” үндэсний хөтөлбөр хэрэгжүүлж эрчүүдийн дундаж наслалтыг уртасгах, хеликобактертэй тэмцэх, эрт оношлох, нянгийн шалтгаант ходоодны архаг үрэвсэл, хорт хавдрын эсрэг арга хэмжээг хэрэгжүүлнэ

1.2.7 Иргэдийг эмийн бус аргаар эрүүлжүүлэх, иргэдийн эрүүл мэндийн боловсролыг дээшлүүлэх мэдээлэл, сургалт, сурталчилгааны загвар төв байгуулна.

1.2.8 “Эрүүл амьдрал- Идэвхтэй хөдөлгөөн” хөтөлбөрийг Аймгийн хэмжээнд хэрэгжүүлж, дасгал хөдөлгөөн, зөв хооллолт, стресс бухимдлаас ангид байх эрүүл амьдралын дадал хэвшлийг төр, хувийн хэвшлийн түншлэлд тулгуурлан хэрэгжүүлнэ.

1.2.9 Өрхийн эмнэлгийн статусыг тодорхой болгож, нэг иргэнээр тооцсон зардал, эрүүл мэндийн даатгалын сангийн санхүүжилтийг оновчтой хэлбэрээр шийдэж иргэндээ ойртсон эрүүл мэндийн үйлчилгээг өргөжүүлнэ.

1.2.10 Бага насны хүүхдийг чийрэгжүүлэх улирлын чанартай Хүүхдийн сувилалыг сум, өрхийн эрүүл мэндийн төвүүдийг түшиглэн байгуулж, хүүхдийн өвчлөл эндэгдлийг бууруулна

1.2.11 Зайлшгүй шаардлагатай эмийн үнийг бууруулж, эрүүл мэндийн даатгалын сангаар олгох эмийн нэр төрлийг нэмэгдүүлж, иргэдийн санхүүгийн хүндрэлийг багасгана

1.2.12 “Чадварлаг эмч” хөтөлбөр хэрэгжүүлж, эмч нарын тогтвор суурьшил, мэргэжлийн ур чадварыг нэмэгдүүлнэ.

1.2.13. Аймгийн Нэгдсэн эмнэлгийн алсын дуудлагын машинд парк шинэчлэл хийж, стандартын шаардлагад нийцсэн автомашинаар хангана

1.3 “ЧАДВАРЛАГ БАГШ - ЧАНАРТАЙ БОЛОВСРОЛ”

1.3.1 Сургуулийн захирал, цэцэрлэгийн эрхлэгчийг мэдлэг чадвар, ажлын гүйцэтгэл, туршлагад нь үндэслэн сонгон шалгаруулж ажиллуулна.

1.3.2 Хүүхдийг ханиад, томуу, халдварт өвчнөөс сэргийлэхээс гадна хөдөө сумдын сургуулийн сурагчдын амралтыг мал төллөх үед амралтын хугацааг уртасгах, богиносгоход анхаарч ажиллана.

811/144190
ИЮА0110 9039376

1.3.3 Нүхэн жорлонтой бүх цэцэрлэг, сургууль, дотуур байрыг орчин үеийн ариун цэврийн өрөөтэй болгож, шаардлагатай тоног төхөөрөмжөөр хангана

1.3.4 Хөгжлийн тэргүүлэх чиглэлээр суралцаж байгаа болон сурлагын амжилтаар тэргүүлэгч оюутнуудад 100 хувь хүртэл сургалтын төлбөрийн тэтгэлэг олгох “Үндэсний тэтгэлэгт хөтөлбөр”-т хамрагдана.

1.3.5 Орон нутаг дахь МСҮТ, Политехник коллеж, их дээд сургуулиудыг дэмжиж, багш нарт орон нутгийн нэмэгдэл олгож, оюутныг төлбөрийн хөнгөлөлттэй нөхцөлөөр суралцуулна.

1.3.6 Шаардлагатай сумдад цэцэрлэг, сургууль болон дотуур байрыг шинээр барих буюу засварлана

1.3.7. ЕБСургууль, цэцэрлэгийн багш ажилтаны нийгмийн болон хөдөлмөрийн үнэлэмж, урамшуулалыг инфляцын түвшинтэй уялдуулж, үе шаттай нэмэгдүүлнэ

1.3.8. Цэцэрлэгийн бүлэг бүрд 2 ээлжийн бүлгийн багш ажиллуулж хүүхэд хүлээн авах, өгөх цагийг уртасгана

1.3.9. Шаардлагатай газарт яслийн анги бүлэг нээх асуудлыг судалж шийдвэрлэнэ

1.3.10 ЕБСургуульд үдийн цай хөтөлбөрийг үдийн хоолны болгон үйлчилгээг чанаржуулж, нэг хүүхдэд ноогдох зардлыг 2 дахин нэмнэ

1.3.11 Сургуулийн дотуур байр, цэцэрлэгийн хүүхдийн хоолны зардлыг 2 дахин нэмэгдүүлнэ

1.3.12 Боловсролын зээлийн сангийн хүртээмжийг нэмэгдүүлж, оюутан ар гэртээ санхүүгийн дарамтгүйгээр суралцахад дэмжлэг үзүүлнэ

1.3.13. “Чадварлаг багш” хөтөлбөр хэрэгжүүлж Залуу гэр бүл, багш нарыг орон сууцжуулах хөтөлбөрт хамруулна

1.4 “ТОГТВОРТОЙ АМЬДРАЛ- АМГАЛАН ГЭР БҮЛ”

1.4.1 Хувь хүн, гэр бүлтэй ажиллах нийгмийн ажилтан, сэтгэл зүйчдийн ажиллах боломжийг нэмэгдүүлнэ.

1.4.2. Хүн бүр угийн бичгээ хөтлөх, цус ойртолтоос урьдчилан сэргийлэх, удмын сангаа хамгаалах үндэсний хөтөлбөрийг үргэлжлүүлэн хэрэгжүүлнэ.

811/144190
ИЮА0110 9039376

1.4.3 Хүн амын бүлгүүд ялангуяа эмэгтэйчүүд, оюутан, залуучууд, тусгай хэрэгцээ (хөгжлийн бэрхшээл)-тэй иргэд, ахмад настан хагас цагаар, гэртээ зайнаас ажиллах уян хатан зохицуулалт бий болгоно.

1.4.4 “Тогтвортой амьдрал- Амгалан гэр бүл” аймгийн дэд хөтөлбөрийг хэрэгжүүлж, гэр бүлд зөвлөлгөө өгөх, гэр бүлийн хүчирхийллээс сэргийлэх үйл ажиллагаа эрхэлдэг төрийн болон төрийн бус байгууллагын үйл ажиллагааг дэмжинэ

1.4.5 Сум, багийн түвшинд ажиллах Хамтарсан багуудыг аймгийн Гэр бүл хүүхэд залуучуудын газар болон олон улсын төсөл хөтөлбөртэй хамтран чадавхжуулна

1.4.6 Гадаадад их, дээд сургууль төгссөн залуучуудаа эх нутагтаа эргэн ирж ажиллаж хөдөлмөрлөх, бизнес эрхлэхэд нь дэмжлэг үзүүлж, эх орон, өссөн төрсөн нутгийнхаа хөгжил цэцэглэлтэнд хувь нэмрээ оруулахыг сайшаан хамтран ажиллана

1.5 “ЗАЛУУЧУУД- ЭХ ОРНЫ ИРЭЭДҮЙ”

1.5.1. Хүүхэд, оюутан, залуучууд, өсвөр үеийнхнийг гадны сөрөг нөлөө, бусдын дарамт, гэмт хэрэгт өртөх, мансууруулах болон сэтгэцэд нөлөөлөх бодис хэрэглэхээс сэргийлэх, цахим орчин дахь аюулгүй байдлыг хангах хөтөлбөр хэрэгжүүлнэ.

1.5.2. Залуу гэр бүлийн эрүүл мэнд, боловсрол, хөдөлмөр эрхлэлт, нийгмийн харилцаа, сэтгэл зүй, хөгжлийн хэрэгцээг дэмжсэн “Залуу гэр бүл” хөтөлбөр хэрэгжүүлнэ.

1.5.3. Хүн амын өсөлтийн бодлогын хүрээнд 3 ба түүнээс дээш хүүхэдтэй гэр бүлд хүүхдийн тооноос хамаарсан татварын хөнгөлөлт үзүүлэх “Тогтвортой амьдрал-амгалан гэр бүл” үндэсний хөтөлбөр хэрэгжүүлнэ.

1.5.4. “Цалинтай ээж” хөтөлбөрийг үргэлжлүүлж, 3 хүртэлх насны хүүхэдтэй эхчүүдэд ялгаварлалгүй олгоно.

1.5.5. Залуучуудын сурч хөгжих, хамтран төлөвших, чөлөөт цагаа зөв боловсон өнгөрөөх Залуучуудын хөгжлийн төвийг байгуулна.

1.6 “ХӨГЖЛИЙН БЭРХШЭЭЛТЭЙ ИРГЭН - ТУСГАЙ ХЭРЭГЦЭЭ”

1.6.1. Аймгийн хэмжээнд байгаа харааны, сонсголын, хөдөлгөөний, сэтгэц мэдрэлийн, оюун ухааны (хөгжлийн бэрхшээл)-тэй иргэдийн судалгааг эрүүл мэндийн ангилалаар судалж бүртгэлжүүлнэ

811/144190
ИЮА0110 9039376

1.6.2. Хөгжлийн бэрхшээлтэй болон / харааны тусгай хэрэгцээт / иргэдийн төрийн бус байгууллагын үйл ажиллагааг дэмжин хамтран ажиллаж үйл ажиллагаагаа хэрэгжүүлэх нөхцөлийг бүрдүүлнэ.

1.6.3. Тусгай хэрэгцээ (хөгжлийн бэрхшээл)-тэй иргэдийг ажлын байраар хангахад холбон зуучилж, ажлын байр бий болгосон ажил олгогчид санхүүгийн урамшуулал олгоно

1.6.4. Тусгай хэрэгцээ (хөгжлийн бэрхшээл)-тэй хүнийг ажиллуулаагүй 25- аас дээш орон тоо тутамд төлөх төлбөрийг аж ахуйн нэгж, төрийн байгууллагуудад тавьж удирдах ажилтны хариуцлагыг нэмэгдүүлнэ.

1.6.5. Байнгын асаргаа шаардлагатай тусгай хэрэгцээ (хөгжлийн бэрхшээл)-тэй хүүхдийг цэцэрлэг, сургуульд хамруулах, олон нийтийн оролцоонд түшиглэн сэргээх засахад дэмжлэг үзүүлнэ.

1.6.6 Хөгжлийн бэрхшээлтэй иргэн, байнгын асаргаа сувилгаанд байдаг ахмадуудад зориулсан төрөлжсөн асрамж, сувилалын үйлчилгээнд хамрагдахад туслалцаа үзүүлнэ.

1.7 АХМАДУУДАА ДЭМЖИЖ-АМЬДРАЛЫГ ДЭЭШЛҮҮЛНЭ

1.7.1. “Насны хишиг” хөтөлбөрийг үргэлжлүүлнэ.

1.7.2. Ахмад настны чөлөөт цагаа үр дүнтэй өнгөрөөх, мэдээлэл авах, хөгжих боломжийг бүрдүүлж, Ахмадын ордоны үйл ажиллагааг тогтмолжуулж сумдад ахмадын хөгжлийн төвүүдийг байгуулна.

1.7.3. Ахмад настны орлогыг нэмэгдүүлэх, мэдлэг туршлагаа хуваалцах, хойч үедээ өвлүүлэн үлдээх, зөвлөх үйлчилгээний санхүүжилтийг нэмэгдүүлж үйлчилгээний нэр төрлийг өргөжүүлнэ


1.7.4. Ахмадуудын тэтгэвэрийг инфляцын түвшинтэй уялдуулан үе шаттай нэмэгдүүлнэ

1.7.5. Ахмадуудын нэрийн дансны үлдэгдлийн тодорхой хэсгийг өвлүүлэх ажлыг хэрэгжүүлнэ.

1.7.6 Ахмад настануудын өдөр өнжүүлэх бүлгийг ажиллуулж, өдрийн болон сэргээх тусламж үйчилгээ, рашаан сувилал, амралтанд жигд хүртээжмтэй хамруулна

1.8 “ӨВ СОЁЛ - ҮНДЭСНИЙ БАХАРХАЛ”

1.8.1. Үндэсний монгол бичгийн хэрэглээг нэмэгдүүлж, “Монгол бичиг”-ээр хэвлэгддэг ном, сонин, сэтгүүлээр аймаг, сумдын номын санг баяжуулна



1.8.2 Түүх, соёлын өвийг сэргээн засварлах, хадгалах хамгаалахад хөрөнгийн дэмжлэг үзүүлж, орон нутгийн засаг захиргааны хариуцлагыг нэмэгдүүлж биет болон биет бус өвийг хамгаална.

1.8.3 Иргэдийн идэвхтэй хөдөлгөөн хийх, уулын болон явган аялал, дугуйн спорт зэрэг нийтийн биеийн тамирын төрлүүдийг дэмжиж, хамрах хүрээг өргөжүүлнэ.

1.8.4. Спортын дасгалжуулагчдыг мэргэшүүлэх сургалтын тогтолцоог сайжруулж, биеийн тамир, спортын арга зүйчийн ажлын байрыг нэмэгдүүлж, сум бүрд биеийн тамирын арга зүйч ажиллуулна.

1.8.5. Аймгийн ХЖТ-ын 800 хүний суудалтай барилгыг ашиглалтад оруулж шаардлагатай тоног төхөөрөмж, боловсон хүчнээр хангана.

Хоёр: ЭДИЙН ЗАСГИЙН БОДЛОГО

Дампуурлаа зарлах хэмжээнд хүрсэн эдийн засгаа өнгөрсөн дөрвөн жилийн хугацаанд сэргээж, хасах үзүүлэлттэй эдийн засгийг 5-7 хувийн өсөлттэй болгож 8.2 их наяд төгрөгийн бонд, зээл, зээлийн хүүгийн төлбөрийг барагдуулж, өрийн дарамтыг бууруулав. Гадаад зах зээлд Монгол Улсад итгэх итгэл сэргэж, улсын зээлжих зэрэглэл хоёр шатаар нэмэгдсэн.

Малчдын орлогыг нэмэгдүүлэхэд анхаарч, махны экспортыг 4-5 дахин нэмэгдүүлэв. Жилийн борлуулалтын орлого 1.5 тэрбум төгрөгөөс бага орлоготой аж ахуйн нэгжүүд нэг хувийн татвар төлдөг болов. Үр тариа, төмс, хүнсний ногоо, жимс жимсгэнэ, тэжээлийн ургамал, модны суулгац үйлдвэрлэгчийн татварыг 50 хувь хөнгөлөв.

Ирээдүйн өв санд 640 тэрбум төгрөг хуримтлуулаад байгаа бөгөөд 2020 онд 1 их наяд төгрөг болж нэмэгдэхээр байна. Монгол Улс анх удаа ирээдүй хойч үедээ өв хөрөнгө хадгалж байна. Ирэх дөрвөн жил хөгжилд хүргэх мега төслүүд хэрэгжүүлж, уул уурхайн бүтээгдэхүүнийг гүн боловсруулах үйлдвэрүүд байгуулна. Үндэсний баялгийн сан байгуулж, эдийн засгийн өсөлтийг хүн бүрд хүргэнэ. Бүс нутгийн дэд бүтцийн сүлжээг сайжруулж, хот, хөдөөгийн ялгааг багасгана.

Газрын тос боловсруулах үйлдвэрийг ашиглалтад оруулж, бензин, шатахууны үнийг 20-30 хувь хямдруулна. “Монгол мал-2” хөтөлбөр, “Атар-4” аяныг зохион байгуулж, Органик хүнс, Эрчим хүч экспортлогч орон болно.

Төр хувийн хэвшлийн түншлэлийг хөгжүүлж, худалдаа, хөрөнгө оруулалтын тааламжтай улс болж жилд 1 сая жуулчин хүлээн авч өмнөх 4 жилийн амжилтаа бүх

талаар ахиулан, хүчирхэг эдийн засагтай, чинээлэг иргэн бүхий орон болох намын мөрийн хөтөлбөрийг орон нутагт хэрэгжүүлнэ.

2.1. “ЭРЧИМТЭЙ ХӨГЖИЛ- ЭДИЙН ЗАСГИЙН ТӨРӨЛЖИЛТ”

2.1.1. Талх, нарийн боов гурилан бүтээгдэхүүний хэрэгцээг аймгийн үйлдвэрлэлээр бүрэн хангана.

2.1.2. “Чинээлэг-Малчин” хөтөлбөрийг хэрэгжүүлж, тариаланчдын нийгмийн асуудлыг шийдэх үндэсний хөтөлбөрт хамрагдана.

2.1.3. Хөдөө аж ахуйн салбарт малчид, тариаланчдын залгамж халааг бэлтгэх “Илгээлтийн эзэн-3” аяныг хэрэгжүүлнэ.

2.1.4. “Ноолуур” хөтөлбөрт хамрагдаж, малчдын орлогыг нэмэгдүүлэхэд анхаарна.

2.1.5. “Монгол мал-2” хөтөлбөрийг хэрэгжүүлж, малыг эрүүлжүүлэх, чанар, ашиг шимийг сайжруулах ажлыг эрчимжүүлж, малын тоог чанарт шилжүүлж ашиг шим, хүртээмжийг сайжруулах, малын генийн санг хамгаалах, биотехнологийн ололтыг нэвтрүүлнэ

2.1.6. Малыг ялган тэмдэглэх, бүртгэлжүүлэх ажлыг эрчимжүүлж, бүртгэл, мэдээллийн нэгдсэн сан, малын гаралтай бүтээгдэхүүний цахим тогтолцоог хөгжүүлж өргөжүүлнэ.


2.1.7. Халдварт өвчинтэй тэмцэх, мал сүргийг бүрэн вакцинжуулах дунд хугацааны стратегийг хэрэгжүүлж, гоц халдварт өвчингүй, аймаг, бүсийг баталгаажуулна.

2.1.8. Сүүний чиглэлийн үхрийн эрчимжсэн аж ахуйн үйлдвэрлэлийг нэмэгдүүлж, дотоодын сүүний үйлдвэрлэл, боловсруулалтыг өсгөж, сүүгээ борлуулж буй малчдад сүүний урамшуулал олгох тогтолцоог бий болгоно.

2.1.9. Төмс, байцаа, манжин, лууван, сонгино, сармисны аймгийн хэрэгцээний 80 хувийг дотоодоосоо хангаж, жимс, жимсгэний тариалалтыг нэмэгдүүлнэ.

2.1.10. Өвлийн хүлэмж, агуулахын аж ахуйг хөгжүүлэх замаар хүнсний ногооны дотоодын хэрэгцээг жилийн турш хангахад аж ахуйн нэгжүүдтэй хамтран ажиллана.

2.1.11. Малын тэжээл, био бордооны үйлдвэрлэлийг бүсчлэн байгуулах үйл ажиллагаанд зээлийн дэмжлэг үзүүлж, өвс тэжээлийн аюулгүй нөөцийг нэмэгдүүлнэ.



2.1.12. Малчдыг өртөг багатай малын тэжээлээр хангах үйлдвэр байгуулж, эрчимжсэн мал аж ахуйг хөгжүүлнэ.

2.2 “БАЙГАЛЬД ЭЭЛТЭЙ- АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛ”

2.2.1. Орон нутгийн аялалын маршрут гаргаж байгаль орчинд ээлтэй, нутгийн иргэд, малчдыг түшиглэсэн тогтвортой Эко аялал жуулчлалыг хөгжүүлнэ.

2.2.2. Аялал жуулчлалын аймгийн мастер төлөвлөгөөг хэрэгжүүлж, гадаад дотоодын байгуулага, хувь хүмүүстэй хамтран ажиллана

2.2.3. Аялал жуулчлалын үйлчилгээний чанар, эрүүл ахуйн шаардлагыг сайжруулж, ажлын байрыг нэмэгдүүлнэ.

2.2.4. Гадаад дотоодын аялал жуулчлагчдын ая тухтай орчныг бүрдүүлж, нутгийн брэнд бүтээгдэхүүн үйлчилгээ үзүүлнэ

2.2.5. Хүүхэд, залуучууд, өсвөр үеийнхний дунд онгон байгаль, нутаг усаа хайрлах, танин мэдэх мэдээлэл, сургалт сурталгааг тогтмол явуулна

2.2.6. “Отгонтэнгэр” аялал жуулчлалын цогцолборыг байгуулна

2.3. ДЭД БҮТЭЦ- ХӨГЖЛИЙН ТУЛГУУР

2.3.1. Улиастай суманд дулааны цахилгаан барьж ашиглалтанд оруулна

2.3.2. Аймгийн төвд цэвэрлэх байгууламж барина

2.3.3. Улиастай-Алтай чиглэлийн хатуу хучилттай авто замын барилгын ажлыг эхлүүлнэ


2.3.4. Шахмал түлшний үйлдвэр барьж, аймаг, сумдын агаарын бохирдлыг бууруулна

2.3.5. Аймаг, сумын төвийн гэр хороололын айл өрхүүдийн цахилгааны шөнийн тарифыг хэрэгжүүлнэ

2.3.6. Нутгийн зам хөтөлбөрийн хүрээнд Арц суурь боомтыг Нөмрөг сумтай, Улиастай хотыг Алтай хоттой, Түдэвтэй, Цэцэн-Уул, Сантмаргаз, Идэр сумдыг Тосонцэнгэл – Улаангом чиглэлийн хэвтээ тэнхлэгийн замтай холбоно.

2.3.7. Их-Уул, Ургамал, Цагаанчулуут, Түдэвтэй сумын ЗДТГ-ын барилгыг барина.

2.3.8. Улиастай-Дөргөн-Мянгад чиглэлд авто замын ажил эхлүүлж, орон нутгийн чанартай гүүрнүүдийг засварлаж, шинээр барина.



Гурав: ЗАСАГЛАЛЫН БОДЛОГО

Засгийн газар тогтвортой, төрийн алба хөнгөн шуурхай, үр дүнтэй ажилладаг болсноор улс орны хөгжлийн бодлогыг алсын хараатай, судалгаа шинжилгээнд үндэслэн боловсруулах улс төрийн болон цаг хугацааны шахалтад орохгүй хэрэгжүүлэх боломж бүрдэнэ.

3.1.1. Монгол Улсын урт хугацааны хөгжлийн үзэл баримтлал “Алсын хараа 2050” -ыг тогтвортой хэрэгжүүлнэ.

3.1.2. Төрийн албаны бүх томилгоонд улс төрийн нөлөөллийг хязгаарлана.

3.1.3. Төрийн захиргааны байгууллагуудын үйл ажиллагааны давхардлыг арилгах, нэгтгэх замаар бүтэц, зохион байгуулалтыг оновчтой, цомхон болгоно.

3.1.4. Төрийн болон нийтийн өмчийн үр ашигтай, зохистой ашиглалт, хэрэглээг дэмжиж, “Үндэсний хэмнэлтийн хөтөлбөрт” хамрагдана.

3.1.5 Үйлдвэрлэл үйлчилгээ, эрхлэхэд шаардагддаг тусгай зөвшөөрөл, гарын үсгийн тоог 3 дахин цөөрүүлж, хугацааг уртасган, давхардсан хяналт, шалгалтын арилгана.

3.1.6 Төрийн байгууллагад байгаа мэдээллийг иргэн, аж ахуйн нэгжээс шаарддаг байдлыг бүрэн халж, иргэд нэг удаа бүртгүүлээд төрийн цахим үйлчилгээг шуурхай авдаг “Нэг иргэн- Нэг бүртгэл” хөтөлбөрийг хэрэгжүүлнэ.


3.1.7. Хүнд сурталгүй төрийн үйлчилгээг нэвтрүүлэн төрийн байгууллагуудын үйлчилгээ, төрийн албан хаагчдыг чадавхыг нэмэгдүүлж, төсвийн зардлыг хэмнэнэ.

3.1.8. Засгийн газрын иргэд, олон нийттэй харилцах “11-11” иргэдийн нэгдсэн мэдээллийн төвийг ажиллуулж, төр, иргэний эргэх холбоог сайжруулна

3.1.9. Цахим ардчиллыг хөгжүүлж, төрийн бодлого, хууль, журам боловсруулан, шийдвэр гаргах үйл явцад иргэдийн саналаа өгөх, хяналт тавих цахимаар оролцох боломжийг бүрдүүлж оролцоог өргөжүүлнэ.

3.1.10. Төрийн байгууллагад хандсан иргэдийн өргөдөл, хүсэлтийг шуурхай шийдэж, тушаал, шийдвэр, үүрэг даалгаврын биелэлтийг цахим хэлбэрээр хянадаг болно.

3.1.11. Төрийн албан хаагч ажил үүргээ гүйцэтгэхдээ танил талдаа давуу тал олгодог, явцуу сонирхол, намын харьяаллаар иргэдэд ялгавартай үйлчилдэгийг зогсооно



3.1.12. Төр, иргэний нийгэм болон бизнесийн байгууллага авлига, ашиг сонирхлын зөрчлөөс ангид байж, авлига, албан тушаалын гэмт хэргийн талаарх мэдээллийг урамшуулах эдийн засгийн хөшүүргийг бий болгоно.

3.1.13. Төрийн албан хаагчийн үйл ажиллагааг үнэлэхдээ ажлын гүйцэтгэл, ёс зүй, сахилга хариуцлагыг шалгуур болгож, ёс зүйн зөрчил гаргасан төрийн алба хаагчид хүлээлгэх хариуцлагыг чангатгана.

3.1.14. Төрийн албанд шинээр томилогдсон иргэнийг орон нутаг, төрийн албаны анхан шатны нэгжид ажиллуулан дадлагажуулах замаар мэдлэг чадвар, туршлагыг нэмэгдүүлнэ.

3.1.15. Төрийн албан хаагчдыг тасралтгүй сургаж хөгжүүлэх цахим сургалтын хөтөлбөрийг үр дүнтэй хэрэгжүүлж, төрийн албан хаагчдын мэдлэг чадвар, хандлага төлөвшлийг бий болгоно

3.1.16. Төрийн байгууллага, эдийн засаг, нийгэм, соёлын хүрээнд жендэрийн эрх тэгш байдлыг хангах тухай хуулийн хэрэгжилтийг хангаж, бүх түвшинд жендэрийн мэдрэмжтэй бодлого хэрэгжүүлнэ.

3.1.17. Нийгмийн хариуцлагатай, хараат бус, мэргэжлийн сэтгүүл зүйг төлөвшүүлэхэд дэмжлэг үзүүлэн, нийгмийг соён гэгээрүүлэх чиглэлд хэвлэл мэдээллийн байгууллагатай хамтран ажиллана.

3.1.18. Аймгийн төвийн болон сумуудын гудамж талбайг камержуулан гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх, таслан зогсоох ажлыг эрчимжүүлнэ.

3.1.19. Зам тээврийн ослоос урьдчилан сэргийлж, орон нутгийн авто замын хөдөлгөөний аюулгүй байдлыг хангах хяналтыг сайжруулна.

3.1.20. Хүнсний баталгаат байдлыг сайжруулах зорилгоор Мэргэжлийн хяналтын газрыг шинэ техник, технологи, багаж хэрэгслээр хангана.

3.1.21. Гамшигт үзэгдлүүд (ган зуд, газар хөдлөлт, хүчтэй шороон шуурга г.м)-ийн тархалт, давтамж, нийгэм, эдийн засагт үзүүлэх нөлөөлөл, эрсдэл аюулын мэдээлэл судалгааг тогтмол явуулж, эрсдэлээс урьдчилан сэргийлэх бодлого арга хэмжээг хэрэгжүүлнэ.

Дөрөв: НОГООН ХӨГЖЛИЙН БОДЛОГО

Өнгөрсөн дөрвөн жилд экосистем, унаган байгалийн тогтвортой байдлыг хадгалах зорилтын хүрээнд цэнгэг усны нөөц, томоохон гол мөрний урсац бүрэлдэх

эхийн 50-аас доошгүй хувийг улсын тусгай хамгаалалтад авах эрх зүйн орчин бүрдүүлсэн. Уул уурхайн олборлолт хийхдээ байгаль экологийг сүйтгэсэн 20 гаруй аж ахуй нэгжийн тусгай зөвшөөрлийг цуцалж, тусгай хамгаалалтай газар нутгийн хэмжээг нэмэгдүүлэх бодлого хэрэгжүүлснээр нийт газар нутгийн 21 хувийг тусгай хамгаалалтад авсан байна.

Ирэх 4 жилд цэнгэг усны нөөц, голын эхийг хамгаалах, хариуцлагатай уул уурхай хөгжүүлэх бодлого хэрэгжүүлж Байгаль орчинд ээлтэй ногоон хөгжлийн бодлогоор ирээдүй хойч үеийн хэрэгцээт боломжийг хадгалж, иргэдээ баталгаат ундны усны нөөцөөр ханган уур амьсгалын өөрчлөлтөд нийцсэн ногоон эдийн засгийг хөгжүүлнэ.

4.1 “ТОГТВОРТОЙ ХӨГЖИЛ- ХАРИУЦЛАГАТАЙ УУЛ УУРХАЙ”

4.1.1. Уул уурхайн лиценз олголтыг олон нийтэд нээлттэй болгож, хууль зөрчиж олгосон зөвшөөрлийг хүчингүй болгоно.

4.1.2. Говийн бүсийн уул уурхайд хайгуул, үйлдвэрлэлийн зориулалттай гүний ус ашиглахыг хязгаарлаж, уул уурхай, үйлдвэрлэлд ашиглах усны хангамжийн зохицуулалт хийнэ.


4.1.3. Уурхайн хаалтын зардлыг дундын хяналтын дансанд төвлөрүүлж, нөхөн сэргээлтийн хариуцлагын даатгал нэвтрүүлэн, байгаль орчныг нөхөн сэргээлгэх хяналтыг сайжруулна.

4.1.4. Олборлох салбарын ил тод байдлын ажлын хэсгийг аймаг болон уул уурхайтай сумдад байгуулж, ажлын хэсгийн гишүүдийн үүрэг хариуцлагыг нэмэгдүүлнэ

4.1.5. Хариуцлагатай уул уурхайг хөгжүүлэхэд уул уурхайн компани орон нутгийн засаг захиргаатай байгуулах “Хамтын ажиллагааны гэрээ”-ний нийгмийн хариуцлага, үр дүн, үр ашгийг нэмэгдүүлнэ.

4.1.6. Уул уурхайн нөлөөлөлд өртөж буй иргэд / Нөлөөлөлийн бүсэд байгаа /-ийн эрүүл аюулгүй орчинд амьдрах болон эдийн засгийн эрхийг хамгаалах, хохирол барагдуулахад нөлөөлөл үзүүлнэ

4.2 “ХҮРЭЭЛЭН БҮЙ ОРЧИН- УУР АМЬСГАЛЫН ӨӨРЧЛӨЛТ”



4.2.1. Хөрс хамгаалах, газрын доройтлыг бууруулах, цөлжилттэй тэмцэх үндэсний хөтөлбөрт хамрагдана.

4.2.2. “Ногоон хэрэм” төсөл хэрэгжүүлж, уул уурхай, газар тариалан, дэд бүтцийн байгууламж, бэлчээр ашиглалтын улмаас эвдрэл, доройтолд орсон газрыг нөхөн сэргээж дахин ашиглах боломжтой болгоно.

4.2.3. Улиастай хот болон бусад сум суурингийн ногоон байгууламжийн эзлэх талбайн хэмжээг 15 хувьд хүргэнэ.

4.2.4. Хүн ам төвлөрсөн аймаг, сумын төвүүдийн үерийн хамгаалалтын далан, суваг, инженерийн барилга байгууламжийг нэмэгдүүлнэ.

4.2.5. Цөлжилтийг бууруулж бэлчээрийг усжуулах, худаг гаргах, хөв цөөрөм байгуулах ажлыг үргэлжлүүлэн малын бэлчээрийн нөөцийг нэмэгдүүлнэ.

4.2.6. Бэлчээрт хөнөөл учруулж буй царцаа, үлийн цагаан оготно гэх мэт хортон шавж, мэрэгч амьтадтай байгаль орчинд халгүй аргаар тэмцэж, холбогдох хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлнэ.

4.2.7. Бэлчээрийн доройтлыг бууруулах газар зохион байгуулалтын тогтолцоо бүрдүүлж, зохистой ашиглан хамгаалж, нөхөн сэргээнэ.

4.2.8. Бэлчээрийг нөхөн сэргээх “Малчдын дундын сан”-г сум бүрт байгуулна.

Тав: ТӨВЛӨРЛИЙГ СААРУУЛАХ ХОТ, ХӨДӨӨГИЙН ТЭНЦВЭРТЭЙ ХӨГЖИЛ

Бүсчилсэн хөгжлийг дэмжих хүрээнд аймгийн төвийг нийслэлтэй холбох хатуу хучилттай замыг барих ажлыг дуусгаж, улмаар сумдыг холбох ажлыг эхлүүлнэ

Ирэх дөрвөн жилд агаар, орчны бохирдлыг аймаг сумдад 70-80 хувь бууруулна. Бүсчилсэн хөгжлийн бодлогыг шинэчилж, орон нутгийн хөгжлийг дэмжих хатуу болон зөөлөн дэд бүтцийн сүлжээг сайжруулна. Хот, хөдөөгийн хөгжлийн ялгааг багасгаж, иргэд нутагтаа сайхан амьдрах боломжийг бүрдүүлнэ.

Аймгийн хэмжээнд 1850 өрхийг инженерийн шийдэл бүхий тохилог орон сууцаар хангаж, худалдаа бэлтгэлийн нэгдсэн тогтолцоог бий болгоно. Орон нутгийн иргэдийн орлогыг нэмэгдүүлж, амьдралын чанарыг сайжруулна.

5.1. ТӨВЛӨРЛИЙГ СААРУУЛАХ- ТЭНЦВЭРТЭЙ ХӨГЖИЛ

5.1.1. Бүсийн хөгжлийн бодлоготой уялдуулан татварын тогтолцоог хөгжүүлж, аймаг, сумдад томоохон аж ахуйн нэгж салбараа байгуулахыг бодлогоор дэмжинэ.

5.1.2. Жижиг, дунд үйлдвэрүүдийн цахим худалдааг дэмжих дэд бүтцийг бий болгон бизнес эрхлэх нэн таатай орчинг бий болгоно.

5.1.3. “Сумын хөгжил” хөтөлбөр хэрэгжүүлж, жишиг сумдын тоог 6-д хүргэж хөрөнгө оруулалтыг үе шаттай нэмэгдүүлнэ.

5.1.4. Аймгийн төвийн гэр хорооллыг дэд бүтцийн шийдэл бүхий амины болон нийтийн орон сууцны хороололд шилжүүлж, “Жишиг хороолол”-ыг орон сууцжуулна .

5.1.5. Сумдад байгуулагдсан иргэдийн бүлэг нөхөрлөл, бизнес эрхлэгчдийг төрийн бодлогоор дэмжин ажлын байрыг нэмэгдүүлнэ.

5.1.6. Цэнгэг усны нөөц, гол мөрний урсац бүрэлдэх эхийг улсын болон орон нутгийн тусгай хамгаалалтад авна.

5.1.7. Ус хангамжийн эх үүсвэрийн барилга байгууламжийг өргөтгөж, баталгаат ундны усаар хангагдсан хүн амын тоог нэмэгдүүлнэ.

5.1.8. Гадаргын усны урсцыг сайжруулж, говийн сумдыг усжуулах төслүүдийг хэрэгжүүлнэ.

5.1.9. Хуримтлалын нэгдсэн сангаар дамжуулан иргэн бүрийн боловсрол, эрүүл мэнд, тэтгэвэр, орон сууц, нийгмийн хамгааллын үйлчилгээг цогцоор нь шийдвэрлэнэ.

5.1.10. Орон сууцны төлөвлөлтөд сургууль, цэцэрлэг, ногоон байгууламж, усан сан, биеийн тамирын талбай бүхий тохилог орчин бүрдүүлэх стандарт хэрэгжүүлнэ.

5.1.12. Орон нутагт нарны эрчим хүчийг дулааны эх үүсвэр болгон ашиглах технологи нэвтрүүлнэ.

5.1.13 Хөдөө орон нутаг, сум багийг харилцаа холбоо, суурин утас, гэр интернетэд холбоно

5.1.14. Шахмал түлшний үйлдвэр барьж, аймаг, орон нутгийн агаарын бохирдлыг бууруулна.

5.1.15. Сумдад ахуйн үйлчилгээний төвүүдийг бий болгож, иргэд халуун ус, үсчин, гоо сайхан, хими цэвэрлэгээний үйлчилгээг тогтмол авах боломжтой болгоно.

5.1.16 Олон төрлийн /орлогод нийцсэн, түрээсийн, ногоон/ орон сууцны хангамжийг нэмэгдүүлж, инженерийн хангамжтай орон сууцаар хангана. Үүнд:

- Гэр хорооллын газрыг дахин төлөвлөж, барилгажуулах төсөл-500
- Зөвшөөрөл олгогдсон барилгажилт төсөл- 800

811144190
ИЮА0110 9039376

ХҮЧЭЭ НЭГТГЭЕ

- Ашиглалтын шаардлага хангахгүй орон сууцны барилгуудыг буулгаж, шинээр барих төсөл- 350
 - Түрээсийн орон сууц- 200
- 5.1.17 Утаагүй Улиастай, сум, суурин хөтөлбөр хэрэгжүүлнэ.

5.1.18 Шаардлагатай сумдад ЗДТГ, сургууль, цэцэрлэг, эмнэлэг барина.

Аймгийн хүүхдийн зусланг сэргээнэ.

